



СЭЛЭНГЭ АЙМГИЙН САНХҮҮГИЙН ХЯНАЛТ,
ДОТООД АУДИТЫН ГАЗАР
ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ

2025 оны 10 сарын 20 өдөр

Дугаар 04

Сүхбаатар сум

Дотоод аудитын хорооны дөрөвдүгээр
хуралдаан

Дотоод аудитын хорооны хурал 2025 оны 10 дугаар сарын 20-ны өдрийн 10 цагаас Засаг даргын хурлын өрөөнд эхэлж 13 цагт дуусав. Хурлын ирц 100 хувьтай хуралдав.

Хуралд:

Дарга:	Н.Лхагвадорж
Нарийн бичгийн дага:	Т.Мөнхзул
Гишүүд:	Т.Одсүрэн, Ө.Сувдаа, Б.Янжинлхам, Х.Мөнхжаргал, А.Дашбат А.Гэрэлмаа

ХЭЛЭЛЦСЭН НЬ:

1. Орхонтуул, Сайхан, Түшиг, Цагааннуур зэрэг сумдын ТТЗ-ын санхүүгийн үйл ажиллагаанд төлөвлөгөөт дотоод аудит хийсэн дүнгийн тухай
2. Сэлэнгэ аймгийн Цагааннуур сумын Бэлчир бүсийн сум дундын ой анги, Ерөө сумын Ерөө бүсийн сум дундын ой ангиудын санхүүгийн үйл ажиллагаанд хийсэн хяналт шалгалтын үр дүнгийн тухай.
3. Орхонтуул, Сайхан Цагааннуур, Түшиг зэрэг сумдын ИТХ-ын ажлын алба болон ЗДТГ, Ерөө сумын Бугант тосгон, Сайхан сумын Номгон тосгон, Орхонтуул сумын Рашаант тосгоны санхүүгийн үйл ажиллагаанд хийсэн хяналт шалгалтын дүнгийн тухай
4. Сант сумын ХХС, Мандал Энержио ОНӨААТҮГ-т өргөдөл гомдлын дагуу санхүүгийн хяналт шалгалт хийсэн дүнгийн тухай.
5. Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтэд хийсэн 3 дугаар улирлын дүнгийн тухай.

СОНССОН НЬ: Санхүүгийн хяналт, дотоод аудитын албаны дарга Т.Одсүрэн хэлэлцэх асуудлын хүрээнд мэдээллийн дарааллын дагуу танилцуулгыг хийв. Үүнд:

1. Орхонтуул, Сайхан, Түшиг, Цагааннуур зэрэг сумдын ТТЗ-ын санхүүгийн үйл ажиллагаанд төлөвлөгөөт дотоод аудит хийсэн дүнгийн тухай

Орхонтуул сумын Засаг дарга

Төсвийн ерөнхийлөн захирагчийн дэргэдэх Санхүүгийн хяналт, дотоод аудитын газраас Орхонтуул сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн үйл ажиллагаанд холбогдох хууль тогтоомжийн дагуу дотоод аудитыг хийж гүйцэтгэхэд илэрсэн алдаа зөрчлийг үндэслэн **"Сайжруулах шаардлагатай"** гэсэн дүгнэлтийг өгсөн.

Аудитаар илэрсэн 723,568.1 мянган төгрөгийн зөрчил дутагдлыг улсын байцаагчийн өгсөн албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилтийг тогтоосон хугацаанд Санхүүгийн хяналт, дотоод аудитын газарт ирүүлэхийг Орхонтуул сумын Засаг дарга Т.Болдбаатар-д хариуцуулсан болно.

Сайхан сумын Засаг дарга

Төсвийн ерөнхийлөн захирагчийн дэргэдэх Санхүүгийн хяналт, дотоод аудитын газраас Сайхан сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн үйл ажиллагаанд холбогдох хууль тогтоомжийн дагуу дотоод аудитыг хийж гүйцэтгэхэд илэрсэн 860,153.4 мянган төгрөгийн алдаа зөрчлийг үндэслэн **"Сайжруулах шаардлагатай"** гэсэн дүгнэлтийг өгч өгсөн.

Аудитаар илэрсэн зөрчил дутагдлыг улсын байцаагчийн өгсөн албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилтийг тогтоосон хугацаанд Санхүүгийн хяналт, дотоод аудитын газарт ирүүлэхийг Сайхан сумын Засаг дарга Б.Мөнхтөр-д хариуцуулсан болно.

Түшиг сумын Засаг дарга

Төсвийн ерөнхийлөн захирагчийн дэргэдэх Санхүүгийн хяналт, дотоод аудитын газраас Түшиг сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн үйл ажиллагаанд холбогдох хууль тогтоомжийн дагуу дотоод аудитыг хийж гүйцэтгэхэд илэрсэн 1,548,028.1 мянган төгрөгийн алдаа зөрчлийг үндэслэн **"Сайжруулах шаардлагатай"** гэсэн дүгнэлтийг өгсөн.

Аудитаар илэрсэн зөрчил дутагдлыг улсын байцаагчийн өгсөн албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилтийг тогтоосон хугацаанд Санхүүгийн хяналт, дотоод аудитын газарт ирүүлэхийг Түшиг сумын Засаг дарга Н.Барамсай-д хариуцуулсан болно.

Цагааннуур сумын Засаг дарга

Төсвийн ерөнхийлөн захирагчийн дэргэдэх Санхүүгийн хяналт, дотоод аудитын газраас Хушаат сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн үйл ажиллагаанд холбогдох хууль тогтоомжийн дагуу дотоод аудитыг хийж гүйцэтгэхэд илэрсэн 82,404.2 мянган төгрөгийн алдаа зөрчлийг үндэслэн **"Сайжруулах шаардлагатай"** гэсэн дүгнэлтийг өгсөн.

Аудитаар илэрсэн зөрчил дутагдлыг улсын байцаагчийн өгсөн албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилтийг тогтоосон хугацаанд Санхүүгийн хяналт, дотоод аудитын газарт ирүүлэхийг Цагааннуур сумын Засаг дарга Г.Цэндсүрэн-д хариуцуулсан болно.

Гишүүд: Орхонтуул, Сайхан, Түшиг, Цагааннуур сумдын Төвлөрүүлэн захирагчийн дотоод аудитаар илэрсэн зөрчил дутагдлыг арилгуулах улсын байцаагчийн өгсөн албан шаардлага, зөвлөмжийг тогтоосон хугацаанд хэрэгжүүлэн ажиллаж Санхүүгийн хяналт, дотоод аудитын газарт биелэлтийг тайлагнах, цаашид зөрчил дутагдлыг давтан гаргахгүй байхыг Орхонтуул, Сайхан, Түшиг, Цагааннуур сумдын Засаг даргад үүрэг болгон хорооны тогтоолоор хяналт шалгалтын дүгнэлтийг хэвээр үлдээхийг хуралд оролцсон гишүүдийн 100 хувийн саналаар дэмжив.

2. Сэлэнгэ аймгийн Цагааннуур сумын Бэлчир бүсийн сум дундын ой анги, Ерөө сумын Ерөө бүсийн сум дундын ой ангиудын санхүүгийн үйл ажиллагаанд хийсэн хяналт шалгалтын үр дүнгийн тухай.

Цагааннуур сумын Бэлчир бүсийн сум дундын ой анги

Сэлэнгэ аймгийн Засаг даргын дэргэдэх Санхүүгийн хяналт, дотоод аудитын газрын даргын баталсан удирдамжийн дагуу Сэлэнгэ аймгийн Цагааннуур сумын Бэлчир бүсийн сум дундын ойн ангийн санхүүгийн үйл ажиллагаанд хийсэн шалгалтад хамрагдсан 2024 он, 2025 оны эхний 3 дугаар улирлын санхүү, төсөв, бүртгэлийн үйл ажиллагаанд хийсэн эрсдэлийн үнэлгээгээр “Бага” эрсдэлтэйд тооцож, төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн, сумын Бэлчир бүсийн сум дундын ойн ангийн эрхлэх асуудлын хүрээнд үйл ажиллагааны горимыг баримталж ажилласан байна гэж дүгнэлээ.

Санхүүгийн хяналт шалгалтаар илэрсэн 30,900.0 мянган төгрөгийн зөрчил дутагдлыг улсын байцаагчийн өгсөн албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилтийг тогтоосон хугацаанд Санхүүгийн хяналт, дотоод аудитын газарт ирүүлэхийг Цагааннуур сумын Бэлчир бүсийн сум дундын ойн ангийн дарга Ж.Эрдэнэцогт-д хариуцуулсан болно.

Ерөө сумын Ерөө бүсийн сум дундын ой анги

Сэлэнгэ аймгийн Засаг даргын дэргэдэх Санхүүгийн хяналт, дотоод аудитын газрын даргын баталсан удирдамжаар Ерөө бүсийн сум дундын ой ангийн санхүүгийн үйл ажиллагаанд хийсэн шалгалтад хамрагдсан 2024 он 2025 оны эхний хагас жилийн улирлын санхүү, төсөв, бүртгэлийн үйл ажиллагаанд хийсэн эрсдэлийн үнэлгээгээр “Дунд” эрсдэлтэйд тооцож, төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн, сумын Ерөө бүсийн сум дундын ойн ангийн эрхлэх асуудлын хүрээнд үйл ажиллагааны горимыг баримталж ажилласан байна гэж дүгнэлээ.

Санхүүгийн хяналт шалгалтаар илэрсэн 36,744.2 мянган төгрөгийн зөрчил дутагдлыг улсын байцаагчийн өгсөн албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилтийг тогтоосон хугацаанд Санхүүгийн хяналт, дотоод аудитын газарт ирүүлэхийг Ерөө сумын Ерөө бүсийн сум дундын ойн ангийн дарга Г.Энхбат-д хариуцуулсан болно.

Гишүүд: Санхүүгийн хяналт шалгалтаар илэрсэн зөрчил дутагдлыг арилгуулах улсын байцаагчийн өгсөн албан шаардлага, зөвлөмжийг тогтоосон хугацаанд хэрэгжүүлэн ажиллаж Санхүүгийн хяналт, дотоод аудитын газарт биелэлтийг тайлагнах, цаашид зөрчил дутагдлыг давтан гаргахгүй байхыг

Цагааннуур, Ерөө сумдын Бэлчир бүсийн сум дундын ойн ангийн дарга, Ерөө бүсийн сум дундын ойн ангийн дарга нарт үүрэг болгон хорооны тогтоолоор хяналт шалгалтын дүгнэлтийг хэвээр үлдээхийг хуралд оролцсон гишүүдийн 100 хувийн саналаар дэмжив.

3. Орхонтуул, Сайхан Цагааннуур, Түшиг зэрэг сумдын ИТХ-ын ажлын алба болон ЗДТГ, Ерөө сумын Бугант тосгон, Сайхан сумын Номгон тосгон, Орхонтуул сумын Рашаант тосгоны санхүүгийн үйл ажиллагаанд хийсэн хяналт шалгалтын дүнгийн тухай

Орхонтуул сумын ЗДТГазар

Сэлэнгэ аймгийн Засаг даргын дэргэдэх Санхүүгийн хяналт, дотоод аудитын газрын даргын баталсан удирдамжаар Орхонтуул сумын ЗДТГ-ын санхүүгийн үйл ажиллагаанд хийсэн шалгалтад хамрагдсан хугацааны төсөв, санхүүгийн гүйцэтгэл, бүртгэл тайлагналт, хууль тогтоомжийн хэрэгжилтийн үйл ажиллагаанд хийсэн эрсдэлийн үнэлгээгээр “Дунд” эрсдэлтэйд тооцож, төсвийн сахилга бат, үйл ажиллагааг сайжруулах шаардлагатай гэж дүгнэлээ..

Санхүүгийн хяналт шалгалтаар илэрсэн зөрчил 180,705.3 мянган төгрөгийн дутагдлыг улсын байцаагчийн өгсөн албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилтийг тогтоосон хугацаанд Санхүүгийн хяналт, дотоод аудитын газарт ирүүлэхийг Орхонтуул сумын Тамгын газрын дарга Д.Мэнд-Амард хариуцуулсан болно.

Орхонтуул сумын ИТХ-ын ажлын алба

Сэлэнгэ аймгийн Засаг даргын дэргэдэх Санхүүгийн хяналт, дотоод аудитын газрын даргын баталсан удирдамжаар Орхонтуул сумын ИТХ-ын санхүүгийн үйл ажиллагаанд хийсэн шалгалтад хамрагдсан хугацааны төсөв, санхүүгийн гүйцэтгэл, бүртгэл тайлагналт, хууль тогтоомжийн хэрэгжилтийн үйл ажиллагаанд хийсэн эрсдэлийн үнэлгээгээр “Дунд” эрсдэлтэйд тооцож, төсвийн сахилга бат, үйл ажиллагааг сайжруулах шаардлагатай гэж дүгнэлээ.

Шалгалтаар илэрсэн зөрчилт үйлдлүүд нь төсвийн хөрөнгийг үр ашиггүй зарцуулах нөхцөл болох тул холбогдох хууль тогтоомжуудын хэрэгжилт, тэдгээрт нийцүүлэн гаргасан дүрэм, журмыг ханган ажиллах шаардлагатай байгааг тус сумын ИТХ-ын дарга, ИТХ-ын нарийн бичгийн дарга, нягтлан бодогч, бусад холбогдох ажилтнуудад танилцуулж, зөвлөмж өгч шалгалтаар илэрсэн зөрчлийг давтан гаргахгүй ажиллахыг анхаарууллаа.

Сайхан сумын ЗДТГазар

Сэлэнгэ аймгийн Засаг даргын дэргэдэх Санхүүгийн хяналт, дотоод аудитын газрын даргын баталсан удирдамжаар Сайхан сумын ЗДТГ-ын санхүүгийн үйл ажиллагаанд хийсэн шалгалтад хамрагдсан хугацааны төсөв, санхүүгийн гүйцэтгэл, бүртгэл тайлагналт, хууль тогтоомжийн хэрэгжилтийн үйл ажиллагаанд хийсэн эрсдэлийн үнэлгээгээр “Дунд” эрсдэлтэйд тооцож, төсвийн сахилга бат, үйл ажиллагааг сайжруулах шаардлагатай гэж дүгнэлээ..

Санхүүгийн хяналт шалгалтаар илэрсэн зөрчил 128,348.4 мянган төгрөгийн дутагдлыг улсын байцаагчийн өгсөн албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилтийг

тогтоосон хугацаанд Санхүүгийн хяналт, дотоод аудитын газарт ирүүлэхийг Сайхан сумын Тамгын газрын дарга С.Мөнхцэцэг-т хариуцуулсан болно.

Сайхан сумын ИТХ-ын ажлын алба

Сэлэнгэ аймгийн Засаг даргын дэргэдэх Санхүүгийн хяналт, дотоод аудитын газрын даргын баталсан удирдамжаар Сайхан сумын ИТХ-ын санхүүгийн үйл ажиллагаанд хийсэн шалгалтад хамрагдсан хугацааны төсөв, санхүүгийн гүйцэтгэл, бүртгэл тайлагналт, хууль тогтоомжийн хэрэгжилтийн үйл ажиллагаанд хийсэн эрсдэлийн үнэлгээгээр “Бага” эрсдэлтэйд тооцож, төсвийн сахилга бат, үйл ажиллагааг сайжруулах шаардлагатай гэж дүгнэлээ.

Шалгалтаар илэрсэн зөрчилт үйлдлүүд нь төсвийн хөрөнгийг үр ашиггүй зарцуулах нөхцөл болох тул холбогдох хууль тогтоомжуудын хэрэгжилт, тэдгээрт нийцүүлэн гаргасан дүрэм, журмыг ханган ажиллах шаардлагатай байгааг тус сумын ИТХ-ын дарга, ИТХ-ын нарийн бичгийн дарга, нягтлан бодогч, бусад холбогдох ажилтнуудад танилцуулж, зөвлөмж өгч шалгалтаар илэрсэн зөрчлийг давтан гаргахгүй ажиллахыг анхаарууллаа.

Цагааннуур сумын ЗДТГазар

Сэлэнгэ аймгийн Засаг даргын дэргэдэх Санхүүгийн хяналт, дотоод аудитын газрын даргын баталсан удирдамжаар Цагааннуур сумын ЗДТГ-ын санхүүгийн үйл ажиллагаанд хийсэн шалгалтад хамрагдсан хугацааны төсөв, санхүүгийн гүйцэтгэл, бүртгэл тайлагналт, хууль тогтоомжийн хэрэгжилтийн үйл ажиллагаанд хийсэн эрсдэлийн үнэлгээгээр “Дунд” эрсдэлтэйд тооцож, төсвийн сахилга бат, үйл ажиллагааг сайжруулах шаардлагатай гэж дүгнэлээ.

Санхүүгийн хяналт шалгалтаар илэрсэн зөрчил 174,558.7 мянган төгрөгийн дутагдлыг улсын байцаагчийн өгсөн албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилтийг тогтоосон хугацаанд Санхүүгийн хяналт, дотоод аудитын газарт ирүүлэхийг Цагааннуур сумын Тамгын газрын дарга Д.Алтанзориг-т хариуцуулсан болно.

Цагааннуур сумын ИТХ-ын ажлын алба

Сэлэнгэ аймгийн Засаг даргын дэргэдэх Санхүүгийн хяналт, дотоод аудитын газрын даргын баталсан удирдамжаар Цагааннуур сумын ИТХ-ын санхүүгийн үйл ажиллагаанд хийсэн шалгалтад хамрагдсан хугацааны төсөв, санхүүгийн гүйцэтгэл, бүртгэл тайлагналт, хууль тогтоомжийн хэрэгжилтийн үйл ажиллагаанд хийсэн эрсдэлийн үнэлгээгээр “Бага” эрсдэлтэйд тооцож, төсвийн сахилга бат, үйл ажиллагааг сайжруулах шаардлагатай гэж дүгнэлээ.

Шалгалтаар илэрсэн зөрчилт үйлдлүүд нь төсвийн хөрөнгийг үр ашиггүй зарцуулах нөхцөл болох тул холбогдох хууль тогтоомжуудын хэрэгжилт, тэдгээрт нийцүүлэн гаргасан дүрэм, журмыг ханган ажиллах шаардлагатай байгааг тус сумын ИТХ-ын дарга, ИТХ-ын нарийн бичгийн дарга, нягтлан бодогч, бусад холбогдох ажилтнуудад танилцуулж, зөвлөмж өгч шалгалтаар илэрсэн зөрчлийг давтан гаргахгүй ажиллахыг анхаарууллаа.

Түшиг сумын ЗДТГазар

Сэлэнгэ аймгийн Засаг даргын дэргэдэх Санхүүгийн хяналт, дотоод аудитын газрын даргын баталсан удирдамжаар Түшиг сумын ЗДТГ-ын санхүүгийн үйл ажиллагаанд хийсэн шалгалтад хамрагдсан хугацааны төсөв, санхүүгийн гүйцэтгэл, бүртгэл тайлагналт, хууль тогтоомжийн хэрэгжилтийн үйл ажиллагаанд хийсэн эрсдэлийн үнэлгээгээр “Дунд” эрсдэлтэйд тооцож, төсвийн сахилга бат, үйл ажиллагааг сайжруулах шаардлагатай гэж дүгнэлээ.

Санхүүгийн хяналт шалгалтаар илэрсэн 476,482.7 мянган төгрөгийн зөрчил дутагдлыг улсын байцаагчийн өгсөн албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилтийг тогтоосон хугацаанд Санхүүгийн хяналт, дотоод аудитын газарт Түшиг сумын Тамгын газрын дарга Б.Уранчимэг-д хариуцуулсан болно.

Түшиг сумын ИТХ-ын ажлын алба

Сэлэнгэ аймгийн Засаг даргын дэргэдэх Санхүүгийн хяналт, дотоод аудитын албаны даргын баталсан удирдамжаар Түшиг сумын ИТХ-ын санхүүгийн үйл ажиллагаанд хийсэн шалгалтад хамрагдсан хугацааны төсөв, санхүүгийн гүйцэтгэл, бүртгэл тайлагналт, хууль тогтоомжийн хэрэгжилтийн үйл ажиллагаанд хийсэн эрсдэлийн үнэлгээгээр “Дунд” эрсдэлтэйд тооцож, төсвийн сахилга бат, үйл ажиллагааг сайжруулах шаардлагатай гэж дүгнэлээ.

Шалгалтаар илэрсэн 41,718.1 мянган төгрөгийн зөрчилт үйлдлүүд нь төсвийн хөрөнгийг үр ашиггүй зарцуулах нөхцөл болох тул холбогдох хууль тогтоомжуудын хэрэгжилт, тэдгээрт нийцүүлэн гаргасан дүрэм, журмыг ханган ажиллах шаардлагатай байгааг тус сумын ИТХ-ын дарга, ИТХ-ын нарийн бичгийн дарга, нягтлан бодогч, бусад холбогдох ажилтнуудад танилцуулж, зөвлөмж өгч шалгалтаар илэрсэн зөрчлийг давтан гаргахгүй ажиллахыг анхаарууллаа.

Ерөө сумын Бугант тосгон

Сэлэнгэ аймгийн Засаг даргын дэргэдэх Санхүүгийн хяналт, дотоод аудитын албаны даргын баталсан удирдамжаар Ерөө сумын Бугант тосгоны санхүүгийн үйл ажиллагаанд хийсэн шалгалтад хамрагдсан хугацааны төсөв, санхүүгийн гүйцэтгэл, бүртгэл тайлагналт, хууль тогтоомжийн хэрэгжилтийн үйл ажиллагаанд хийсэн эрсдэлийн үнэлгээгээр “Дунд” эрсдэлтэйд тооцож, төсвийн сахилга бат, үйл ажиллагааг сайжруулах шаардлагатай гэж дүгнэлээ.

Шалгалтаар илэрсэн 36,744.2 мянган төгрөгийн зөрчилт үйлдлүүд нь төсвийн хөрөнгийг үр ашиггүй зарцуулах нөхцөл болох тул холбогдох хууль тогтоомжуудын хэрэгжилт, тэдгээрт нийцүүлэн гаргасан дүрэм, журмыг ханган ажиллах шаардлагатай байгааг тус сумын Бугант тосгоны дарга, нягтлан бодогч, бусад холбогдох ажилтнуудад танилцуулж, зөвлөмж өгч шалгалтаар илэрсэн зөрчлийг давтан гаргахгүй ажиллахыг анхаарууллаа.

Сайхан сумын Номгон тосгон

Сэлэнгэ аймгийн Засаг даргын дэргэдэх Санхүүгийн хяналт, дотоод аудитын албаны даргын баталсан удирдамжаар Сайхан сумын Номгон тосгоны санхүүгийн үйл ажиллагаанд хийсэн шалгалтад хамрагдсан хугацааны төсөв, санхүүгийн

гүйцэтгэл, бүртгэл тайлагналт, хууль тогтоомжийн хэрэгжилтийн үйл ажиллагаанд хийсэн эрсдэлийн үнэлгээгээр “Бага” эрсдэлтэйд тооцож, төсвийн сахилга бат, үйл ажиллагааг сайжруулах шаардлагатай гэж дүгнэлээ.

Шалгалтаар илэрсэн зөрчилт үйлдлүүд нь төсвийн хөрөнгийг үр ашиггүй зарцуулах нөхцөл болох тул холбогдох хууль тогтоомжуудын хэрэгжилт, тэдгээрт нийцүүлэн гаргасан дүрэм, журмыг ханган ажиллах шаардлагатай байгааг тус сумын Бугант тосгоны дарга, нягтлан бодогч, бусад холбогдох ажилтнуудад танилцуулж, зөвлөмж өгч шалгалтаар илэрсэн зөрчлийг давтан гаргахгүй ажиллахыг анхаарууллаа.

Орхонтуул сумын Рашаант тосгон

Сэлэнгэ аймгийн Засаг даргын дэргэдэх Санхүүгийн хяналт, дотоод аудитын албаны даргын баталсан удирдамжаар Орхонтуул сумын Рашаант тосгоны санхүүгийн үйл ажиллагаанд хийсэн шалгалтад хамрагдсан хугацааны төсөв, санхүүгийн гүйцэтгэл, бүртгэл тайлагналт, хууль тогтоомжийн хэрэгжилтийн үйл ажиллагаанд хийсэн эрсдэлийн үнэлгээгээр “Дунд” эрсдэлтэйд тооцож, төсвийн сахилга бат, үйл ажиллагааг сайжруулах шаардлагатай гэж дүгнэлээ.

Шалгалтаар илэрсэн 7,572.4 мянган төгрөгийн зөрчилт үйлдлүүд нь төсвийн хөрөнгийг үр ашиггүй зарцуулах нөхцөл болох тул холбогдох хууль тогтоомжуудын хэрэгжилт, тэдгээрт нийцүүлэн гаргасан дүрэм, журмыг ханган ажиллах шаардлагатай байгааг тус сумын Бугант тосгоны дарга, нягтлан бодогч, бусад холбогдох ажилтнуудад танилцуулж, зөвлөмж өгч шалгалтаар илэрсэн зөрчлийг давтан гаргахгүй ажиллахыг анхаарууллаа.

Гишүүд: Орхонтуул, Сайхан, Цагааннуур, Түшиг зэрэг сумдын ИТХ-ын ажлын алба болон ЗДТГ, Ерөө сумын Бугант тосгон, Сайхан сумын Номгон тосгон, Орхонтуул сумын Рашаант тосгоны санхүүгийн үйл ажиллагаанд хийсэн хяналт шалгалтын дүнгийн тухай илэрсэн зөрчил дутагдлыг арилгуулах улсын байцаагчийн өгсөн албан шаардлага, зөвлөмжийг тогтоосон хугацаанд хэрэгжүүлэн ажиллаж Санхүүгийн хяналт, дотоод аудитын газарт биелэлтийг тайлагнах, цаашид зөрчил дутагдлыг давтан гаргахгүй байхыг Орхонтуул, Сайхан, Цагааннуур, Түшиг зэрэг сумдын ИТХ-ын ажлын алба болон ЗДТГ, Ерөө сумын Бугант тосгон, Сайхан сумын Номгон тосгон, Орхонтуул сумын Рашаант тосгон, сумдын Засаг даргад үүрэг болгон хорооны тогтоолоор хяналт шалгалтын дүгнэлтийг хэвээр үлдээхийг хуралд оролцсон гишүүдийн 100 хувийн саналаар дэмжив.

4. Сант сумын ХХС, Мандал Энергио ОНӨААТҮГ-т өргөдөл гомдлын дагуу санхүүгийн хяналт шалгалтын дүнгийн тухай

Сант сумын ХХС

Сэлэнгэ аймгийн Засаг даргын дэргэдэх Санхүүгийн хяналт, дотоод аудитын албаны даргын баталсан удирдамжаар Сант сумын Хоршоо хөгжүүлэх сангийн санхүүгийн үйл ажиллагаанд хийсэн шалгалтад хамрагдсан хугацааны төсөв, санхүүгийн гүйцэтгэл, бүртгэл тайлагналт, хууль тогтоомжийн хэрэгжилтийн үйл ажиллагаанд хийсэн эрсдэлийн үнэлгээгээр “Бага” эрсдэлтэйд тооцож, төсвийн сахилга бат, үйл ажиллагааг сайжруулах шаардлагатай гэж дүгнэлээ.

Санхүүгийн хяналт шалгалтаар илэрсэн зөрчил дутагдлыг улсын байцаагчийн өгсөн зөвлөмжийн хэрэгжилтийг тогтоосон хугацаанд Санхүүгийн хяналт, дотоод аудитын газарт ирүүлэхийг Сант сумын Хоршоо хөгжүүлэх сан хариуцсан мэргэжилтэн Э.Энхчимэг-т хариуцуулсан болно.

Мандал сумын Мандал Энергио

Сэлэнгэ аймгийн Засаг даргын дэргэдэх Санхүүгийн хяналт, дотоод аудитын албаны даргын баталсан удирдамжаар Мандал сумын “Мандал Энергио”-н санхүүгийн үйл ажиллагаанд хийсэн шалгалтад хамрагдсан хугацааны төсөв, санхүүгийн гүйцэтгэл, бүртгэл тайлагналт, хууль тогтоомжийн хэрэгжилтийн үйл ажиллагаанд хийсэн эрсдэлийн үнэлгээгээр “Дунд” эрсдэлтэйд тооцож, төсвийн сахилга бат, үйл ажиллагааг сайжруулах шаардлагатай гэж дүгнэлээ.

Санхүүгийн хяналт шалгалтаар илэрсэн зөрчил дутагдлыг улсын байцаагчийн өгсөн зөвлөмжийн хэрэгжилтийг тогтоосон хугацаанд Санхүүгийн хяналт, дотоод аудитын газарт ирүүлэхийг Мандал сумын “Мандал Энергио”-н удирдлагад хариуцуулсан болно.

Орхонтуул, Сайхан, Цагааннуур, Түшиг зэрэг сумдын ИТХ-ын ажлын алба болон ЗДТГ, Ерөө сумын Бугант тосгон, Сайхан сумын Номгон тосгон, Орхонтуул сумын Рашаант тосгоны санхүүгийн үйл ажиллагаанд хийсэн хяналт шалгалтын дүнгийн тухай илэрсэн зөрчил дутагдлыг арилгуулах улсын байцаагчийн өгсөн албан шаардлага, зөвлөмжийг тогтоосон хугацаанд хэрэгжүүлэн ажиллаж Санхүүгийн хяналт, дотоод аудитын газарт биелэлтийг тайлагнах, цаашид зөрчил дутагдлыг давтан гаргахгүй байхыг Орхонтуул, Сайхан, Цагааннуур, Түшиг зэрэг сумдын ИТХ-ын ажлын алба болон ЗДТГ, Ерөө сумын Бугант тосгон, Сайхан сумын Номгон тосгон, Орхонтуул сумын Рашаант тосгон, сумдын Засаг даргад үүрэг болгон хорооны тогтоолоор хяналт шалгалтын дүгнэлтийг хэвээр үлдээхийг хуралд оролцсон гишүүдийн 100 хувийн саналаар дэмжив.

Гишүүд: Сант сумын ХХС, Мандал Энергио ОНӨААТҮГ-т өргөдөл гомдлын дагуу санхүүгийн хяналт шалгалтын дүнгийн тухай илэрсэн зөрчил дутагдлыг арилгуулах улсын байцаагчийн өгсөн албан шаардлага, зөвлөмжийг тогтоосон хугацаанд хэрэгжүүлэн ажиллаж Санхүүгийн хяналт, дотоод аудитын газарт биелэлтийг тайлагнах, цаашид зөрчил дутагдлыг давтан гаргахгүй байхыг Сант сумын ХХС, Мандал Энергио ОНӨААТҮГ-ын удирдлагад үүрэг болгон хорооны тогтоолоор хяналт шалгалтын дүгнэлтийг хэвээр үлдээхийг хуралд оролцсон гишүүдийн 100 хувийн саналаар дэмжив.

Т.Одсүрэн: Санхүүгийн хяналт дотоод аудитын албанаас 2025 онд хийх хяналт шалгалтын төлөвлөгөөний дагуу аймгийн Засаг даргын баталсан удирдамжаар “Шилэн дансны тухай” хууль, Загийн газрын 2016 оны 01 дүгээр сарын 11-ний өдрийн 29 дүгээр тогтоолоор батлагдсан “Шилэн дансны цахим хуудсанд тавигдах мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын хэрэгжилтэд хяналт шалгалтыг гүйцэтгэхэд аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн харьяа нийт 128 байгууллага, орон нутгийн өмчит аж ахуй нэгж газар, тусгай сангийн мэдээлэл байршуулалтад нийцлийн аудитыг хийж гүйцэтгэсэн.

Сэлэнгэ аймгийн Санхүүгийн хяналт дотоод аудитын албанаас 2025 оны 3 дугаар улирлын шилэн дансны мэдээлэл байршуулалтад хийсэн аудитаар нийт

16,822 мэдээлэл байршуулахаас 15,792 мэдээлэл байршуулж 527 мэдээллийг огт байршуулаагүй, 394 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн, аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн шилэн дансны тухай хууль тогтоомжийн хэрэгжилт 2025 оны 3-р улирлын байдлаар 91.5 хувьтай байгаа нь эхний хагас жилийн дүнгээс 5,4 хувиар 2025 оны 1 дүгээр улирлаас 3,1 хувиар тус тус буурсан үзүүлэлттэй байна.

Шилэн дансны мэдээлэл байршуулалтын нийт хувь буурсан нь мэдээллийн чанар болоод мэдээлэл байршуулах хугацаа дээр **“Сайжруулах шаардлагатай”** гэсэн дүгнэлтийг өгч мэдээллийн ил тод байдлыг улам сайжруулах шаардлагатай байна.

ШИЙДВЭРЛЭСЭН НЬ:

1. Орхонтуул, Сайхан, Түшиг, Цагааннуур зэрэг сумдын сумдын төсвийн төвлөрүүлэн захирагчийн санхүүгийн үйл ажиллагаанд холбогдох хууль тогтоомжийн дагуу дотоод аудитыг хийж гүйцэтгэхэд илэрсэн алдаа зөрчлийг үндэслэн **“Сайжруулах шаардлагатай”** гэсэн дүгнэлтийг,
2. Сэлэнгэ аймгийн Цагааннуур сумын Бэлчир бүсийн сум дундын ой анги, Сайхан сумын ИТХ, Сайхан сумын Номгон тосгоны Захирагчийн алба, Сант сумын Хоршоо хөгжүүлэх сан, Цагааннуур сумын ИТХ нарын санхүүгийн үйл ажиллагаанд холбогдох хууль тогтоомжийн дагуу дотоод аудитыг хийж гүйцэтгэхэд илэрсэн алдаа зөрчлийг үндэслэн **“Бага”** гэсэн дүгнэлтийг тус тус өглөө.
3. Ерөө бүсийн сум дундын ойн анги Орхонтуул сумын ИТХ, Орхонтуул сумын рашаант тосгоны Захирагчийн алба, Сайхан сумын ЗДТГ, Цагааннуур сумын ЗДТГ, Түшиг сумын ЗДТГ, Түшиг сумын ИТХ нарын санхүүгийн үйл ажиллагаанд холбогдох хууль тогтоомжийн дагуу дотоод аудитыг хийж гүйцэтгэхэд илэрсэн алдаа зөрчлийг үндэслэн **“Дунд”** гэсэн дүгнэлтийг тус тус өглөө.
4. Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтэд хийсэн 3 дугаар улирлын нийцлийн аудитыг хангалттай гэсэн дүгнэлтийг,
5. Орон нутгийн төсвийн болон өмчийн хөрөнгийг үр ашигтай захиран зарцуулахад төсвийн удирдлагыг хэрэгжүүлэх шийдвэр, үйл ажиллагаа ил тод, нээлттэй, ойлгомжтой байх хуулиар хүлээсэн үүргээ сайжруулах.

Гишүүд: Дотоод аудитын хорооны тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Дотоод аудитын хорооны нарийн бичгийн дарга (Т.Мөнхзул)-д үүрэг болгох нь зүйтэй гэж хорооны гишүүдийн 100 хувийн саналаар дэмжиж тогтоолын төслийг батлахаар санал нэгдэв.

ТАНИЛЦСАН:

ДОТООД АУДИТЫН ХОРООНЫ
ДАРГА


Н.ЛХАГВАДОРЖ

ТЭМДЭГЛЭЛ ХӨТӨЛСӨН:

АХЛАХ ДОТООД АУДИТОР


Т.МӨНХЗУЛ